

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА *Д.СҮХЭЭ*

9043446 2020030036

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРЭЭНД 2022 ОНД АВЛИГА, ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.02.14

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх			
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.	1.1. Хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилогдох албан тушаалтны Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг АТГ-ын Дүн шинжилгээний хэлтэст хянуулж, томилох.	Албан тушаалтныг томилогдохдоо Хууль, тогтоомжийн дагуу ХАСУМ гаргуулж томилсон байна.
		1.2. Төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах, албан тушаалтнуудын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч АТГ-т тайлан, нэрсийг хуулийн хугацаанд хүргүүлэх.	Хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна.
		1.3. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон сурталчилгааны самбар, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах.	Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнах.
		1.4. ЭМГ-ын сайтад Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг цахим хуудсанд байршуулж, иргэдийг мэдээллээр хангах боломж нөхцлийг бүрдүүлэх.	Цахим болон веб сайтанд байршуулсан байна.
		1.5. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдэнд үйлчилгээ үзүүлж буй бүх түвшний мэргэжлийн болон захиргааны байгууллага, албан тушаалтнуудад зориулсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах.	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн мэдээллээр хангагдаж, сургалт зохион байгуулагдсан байна.
2	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуур болон албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дээшлүүлэх	2.1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах.	-Холбогдох хууль журмын дагуу томилж, дэвшүүлсэн байх -Шинээр томилогдох нийтийн албан тушаалтныг хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг хянуулсны дараа томилсон байх.
		2.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил, өргөдөл, гомдлыг судалж тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Өргөдөл, гомдлын программын бүртгэл утга, агуулга, шийдвэрлэлтээрээ ангилагдан бүрэн бүртгэгдэж хэвшсэн байна.

3	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах.	3.1.Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, ААНБ болон гадаадын хандив, зээл тусламжийн ил тод байдлыг хангаж ажиллах.	Иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэж ажиллах.
4	Хяналт хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх.	4.1.Тендерийн үнэлгээний хороонд ажиллаж байгаа ажилтнуудын ашиг сонихлын зөрчилгүйг илэрхийлэх мэдэгдлийг тогтмол авч хэвших. 4.2.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхижүүлэх, хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг мэдээлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах.	Үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй байна. Хяналт, хариуцлагын тогтолцоо сайжирна